

ХЯНАЛТЫН ЖУРМААР ГОМДОЛ ГАРГАХ НЬ

2024 он 03 сарын 27

Улаанбаатар хот

"Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 889 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2024 оны 03 дүгээр сарын 05-ны өдрийн 221/МА2024/0152 дугаар магадлалыг бүхэлд нь эс зөвшөөрч, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2-т заасан үндэслэлээр дараах гомдлыг гаргаж байна.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийн ХЯНАВАЛ хэсгийн 2.6-д "... Маргаан таслах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 55 дугаар албан бичиг нь Татварын ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.9, 47.10, 47.19-д заасан Маргаан таслах зөвлөлөөс татварын акттай холбогдуулан гаргасан гомдлыг хянаад гаргасан шийдвэрт хамаарахааргүй байна.

2.7. Түүнчлэн Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д "Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно" гэж заажээ. Өөрөөр хэлбэл, Маргаан таслах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 55 дугаар албан бичгээр нэхэмжлэгч компаниас гаргасан Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.2-т заасан хөөн хэлэлцэх хугацаа сэргээлгэх тухай хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж буцаасан байх тул энэ нь хуульд заасан захиргааны актын шинжийг агуулсан гэж үзэхээргүй байна" гэж дүгнэн Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр 54.1.1, 109 дүгээр зүйлийн 109.2-т зааснаар Татварын ерөнхий газрын дэргэдэх Татварын маргаан таслах зөвлөлд холбогдуулан гаргасан "Татварын ерөнхий газрын 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн НА-21220000075 дугаартай "Нөхөн ногдуулалтын акт"-д гомдол гаргах хугацаа сэргээлгэх хүсэлтийг хүлээн авахаас татгалзсан үйлдлийг хууль бус болохыг тогтоолгох, гомдол гаргах хугацаа сэргээхийг даалгах" нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Маргаан таслах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 55 дугаар албан бичиг нь Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д зааснаар захиргааны акт нь дараахь шаардлагыг хангасан байх шаардлагатай. Үүнд:

- Захиргааны байгууллагаас гаргасан;
- Тодорхой нэг тохиолдлыг зохицуулсан;
- Нийтийн эрх зүйн хүрээнд;
- Гадагш чиглэсэн;
- Эрх зүйн шууд үр дагавар бий болгосон;
- Амаар болон бичгээр гаргасан;
- Захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагаа.

Дээрх тогтоол нь захиргааны байгууллага буюу Татварын ерөнхий газрын дэргэдэх Татварын маргаан таслах зөвлөлөөс гарсан манай компанид оногдуулсан хууль бус "Нөхөн ногдуулалтын акт"-д гомдол гаргах эрх олгох эсэхийг шийдвэрлэсэн буюу тодорхой нэг тохиолдлыг шийдвэрлэсэн, нийтийн эрх зүйн хүрээнд буюу захиргааны байгууллагаас манай компанид чиглэсэн хуульд заасан чиг үүргийн дагуу гаргасан, эрх зүйн шууд үр дагаварыг манай компанид бий болгосон, захирамжилсан шинжтэй бичгээр гарсан захиргааны акт юм. Тиймээс Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс

нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь үндэслэлгүй болжээ.

Харин Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 889 дүгээр шийдвэр нь нэхэмжлэгчийн маргаж буй бүхий л үндэслэлд бүрэн хууль зүйн дүгнэлт өгөөгүй байдаг. Тодруулбал, Захиргааны ерөнхий хуулийн 94.1-т “захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана” гэж заасан. Уг хуулийн хэм хэмжээнээс үзвэл татвар төлөгчид хуульд заасан журмын дагуу мэдэгдээгүй гэж үзэж байна.

Учир нь Хэргийн материалд 2019 оны 01 сарын 01-ны өдрийн А-19/10 дугаар, 2022 оны 06 сарын 15-ны өдрийн 06/01 дугаар, 2022 оны 09 сарын 01-ны өдрийн 09/01 дугаартай итгэмжлэлүүд тус тус авагдсан байна. Эдгээд гурван итгэмжлэлийг БНХАУ-ын иргэн DONG XIAOZHONG /Донг Шиасонг/-аас тус тус олгосон.

Уг хятад иргэн нь Монголоор уншиж бичих нь байтугай ярьж ч чадахгүй. Хэрэгт авагдсан итгэмжлэлүүд нь бүгд монгол хэл дээр байна. Иймээс тухайн татвар төлөгчийн хүсэл зориг бүрэн илэрхийлэгдээгүй гэж үзэхээр байна.

Хэрэгт авагдсан итгэмжлэлүүд болох БНХАУ-ын иргэнээс Б.Ариунболдод олгосон итгэмжлэлүүд нь бүгд алдаатай байгааг харж болно. Тухайлбал 2022 оны 06 сарын 15-ны өдрийн 06/01 дугаартай итгэмжлэл нь 2022 оны 06 сарын 15-ны өдөр олгосон хэрнэ 2021.03.31-ээс 2021.07.01-хүртэл гэж өнгөрсөн цаг дээр төлөөлөх эрх олгосон алдаатай, 2022 оны 08 сарын 31-ны өдрийн 08/15 дугаартай итгэмжлэл нь 2022 оны 08 сарын 31-ны өдөр олгосон хэрнэ 2022.03.31-ээс 2022.07.01 хүртэл гэж мөн л өнгөрсөн цаг дээр төлөөлөх эрх олгосон алдаатай итгэмжлэлүүд байгаагаас түүний Монгол хэл бичгийн мэдлэггүй нь нотлогдоно.

Гадаад улсын иргэн нь Монгол хэл мэдэхгүй бол баримт бичиг үйлдэхдээ өөрийн эх хэл дээр үйлдэж, тухайн эх хэл дээр үйлдэгдсэн баримтыг баталгаат орчуулгаар орчуулуулж баталгаат орчуулгын тамга тэмдэг дарснаар сая хүчин төгөлдөр хүсэл зоригийн илэрхийлэл болно. Хэрэгт авагдсан баримтуудаас харвал эх хэл дээрээ олгосон итгэмжлэл авагдаагүй байна. Иймээс компанийн эрх барих этгээд буюу татвар төлөгчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн хүсэл зориг илэрхийлэгдээгүй гэж үзэж байна.

Хариуцагчаас Б.Ариунболдод Нөхөн ногдуулалтын актыг 2022 оны 09 сарын 22-ны өдөр гардуулсан гомдол гаргах хугацаа сэргээлгэх хүсэлтээ үүнээс 3 сарын дараа гаргах ёстой энэ хугацаандаа гаргаагүй буюу 2023 оны 05 сард гаргаж 8 сар хэтрүүлсэн гэж тайлбарласан нь үндэслэлгүй.

Учир нь Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйл нь гагцхүү захиргааны актыг хуульд заасан журмын дагуу мэдэгдсэн тохиолдолд хэрэглэгдэх хуулийн хэм хэмжээ юм.

Нөгөөтэйгүүр, нөхөн сэргээх хүсэлтийг хугацаа хэтэрснээс хойш 3 сарын дотор гаргана, энэхүү 3 сарын дотор гаргах боломжгүй бол тухайн шалтгаанаа нотлох боломжоор хангаж ёстой, гэтэл нотлох боломж олгоогүй, хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж, хүсэлтийг буцааж шийдсэн нь захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагааны зарчмыг зөрчсөн гэж үзэж байна.

Өөрөө хэлбэл, Захиргааны ерөнхий хуулийн 4-р зүйлийн 4.2.6-д “бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд тэдгээрт урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах” зарчмыг баримтална гэж заасан байхад оролцоог хангаагүй хүлээн авахаас татгалзсан нь хууль бус гэж үзэж байна.

Захиргааны ерөнхий хуулийн 13-р зүйлийн 13.1-д “Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцогч гэж захиргааны байгууллагад өргөдөл, хүсэлт гаргасан этгээд,


захиргааны акт, захиргааны гэрээний эрх зүйн үйлчлэл шууд болон шууд бусаар чиглэсэн этгээд болон захиргааны байгууллагаас шийдвэр гаргах ажиллагаанд татан оролцуулсан этгээдийг ойлгоно” гэж заасан ба энэ хуулийн 15 дугаар зүйлд оролцогчийн эрхийг заасан байгаа. Үүний 15.1.4-д “захиргааны шийдвэр гаргахаас өмнө оролцогч нотлох баримт гаргах, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн өгөх” гэж заасан эрхийг эдлүүлээгүй нэмэлт тайлбар баримт авалгүйгээр 3 сар хэтрүүлсэн гэж үзэж хүлээн авахаас татгалзсан нь хууль бус юм.

- Судлан тогтоох зарчим: Захиргаа нь гарч болох гомдол шаардлагыг урьдчилан тооцоолон аль болох боломжит судалгааг хийж нөхцөл байдлыг тодорхой болгох ёстой бөгөөд тухайн тохиолдолд ач холбогдолтой бүхий л нөхцөл байдлыг нарийвчлан судалсан байх ёстой.
- Сонсох ажиллагаа: Захиргаа нь аливаа шийдвэр гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгоно.
- Нотлох зарчим: Хуульд заасан журмын дагуу захиргааны байгууллага нь нөхцөл байдлыг тогтоохдоо шаардлагатай нотлох баримтыг цуглуулах үүрэгтэй.

Иймээс Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 889 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2024 оны 03 дүгээр сарын 05-ны өдрийн 221/МА2024/0152 дугаар магадлалыг бүхэлд нь хүчингүй болгож, анхан шатны шүүхэд буцааж өгнө үү.

- УТХ төлсөн баримт

Гомдол гаргасан



Б.Энхзаяа

Утас: 86128866